

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД, ЭРҮҮЛ МЭНДИЙН
САЙД, САНГИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2017 оны 5 сарын 3 өдөр

Дугаар А/115 / А/176 / 142

Улаанбаатар хот


Журам батлах тухай


Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.2, 39.3 дахь заалт, Засгийн газрын 2009 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан “Зарим цогцос оршуулах журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Шүүх эмнэлгийн төлбөрт үйлчилгээний журам”-ыг нэгдүгээр, “Шүүх эмнэлгийн үйлчилгээний төлбөрийн хэмжээ”-г хоёрдугаар, “Эзэнгүй цогцос оршуулах зардлын жишиг хэмжээ”-г гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн /Д.Батжаргал/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү журам батлагдсантай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2008 оны 170/271 дүгээр тушаалаар батлагдсан “Шүүх эмнэлгийн төлбөрт үйлчилгээний журам”-ыг хүчингүй болсонд тооцсугай.





ШҮҮХ ЭМНЭЛГИЙН ТӨЛБӨРТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Энэхүү журмын зорилго нь шүүх эмнэлгээс үзүүлж буй төлбөрт үйлчилгээний хэмжээг тогтоох, чөлөөлөх, төлбөр төлөх, хураах, түүнийг тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Шүүхийн шинжилгээний байгууллага нь шүүх эмнэлгээс үзүүлж буй төлбөрт үйлчилгээндээ Төсвийн тухай хууль, Шүүхийн шинжилгээний тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон бусад хууль тогтоомж, тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журам болон энэхүү журмыг мөрдлөг болгоно.

Хоёр. Шүүх эмнэлгийн төлбөрт үйлчилгээний төрөл

2.1. Дараах үйлчилгээнээс төлбөр авна. Үүнд:

- 2.1.1. Амбулаторийн үзлэг, оношилгоо, шинжилгээ;
- 2.1.2. Лабораторийн шинжилгээ;
- 2.1.3. Цогцост хийх шинжилгээ.

Гурав. Төлбөр төлөх

3.1. Үйлчилгээний төлбөрийг шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдийн тогтоол, захирамж, хүсэлтээр шинжилгээ хийлгэж, дүгнэлт гаргуулсан Монгол улсын болон гадаад улсын иргэн төлнө.

3.2. Ар гэрийнхний хүсэлтийн дагуу шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдийн тогтоол, шийдвэр гарч шарилыг дахин шинжилсэн тохиолдолд төлбөрийг талийгаачийн ар гэр хариуцна.

3.3. Гэмт хэргийг илрүүлэх зорилгоор шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд шарилыг дахин шинжлүүлсэн тохиолдолд гарсан зардлыг тухайн байгууллага хариуцна.

3.4. Амьдралын баталгаажих түвшингээс доогуур орлоготой, нэн ядуу иргэнийг холбогдох байгууллагын тодорхойлолт болон бусад нотлох баримтыг үндэслэн үзлэг, цогцост хийх шинжилгээний төлбөрөөс чөлөөлж болно.

Дөрөв. Төлбөрт үйлчилгээний орлогын бүртгэл зарцуулалт

4.1. Энэхүү журмын хавсралтаар батлагдсан төлбөрийг Төрийн сан дахь байгууллагын дансанд шилжүүлж, төлбөрийн баримтыг бүртгэлийн ажилтанд авчирч өгнө.

4.2. Орон нутаг болон нийслэлийн Налайх, Багануур дүүрэгт төлбөрийг Нийслэлийн шүүхийн шинжилгээний газар, Аймгийн шүүхийн шинжилгээний албаны Төрийн сангийн дансанд төвлөрүүлнэ.


4.3.Төлбөрт үйлчилгээний орлогоор Шүүх эмнэлгийн үзлэг шинжилгээ, оношилгооны зардлыг санхүүжүүлнэ.

4.4. Журмын хэрэгжилтийг Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн Санхүү төлөвлөлт, хангамжийн газар, Шүүх эмнэлгийн шинжилгээний газар болон Тусгай шинжилгээний газар зохион байгуулж, Шүүхийн шинжилгээний төв байгууллагын Тэргүүн дэд дарга хяналт тавьж ажиллана.

Тав. Хүлээлгэх хариуцлага

5.1. Энэхүү журмыг зөрчсөн албан хаагчийн үйлдэл гэмт хэргийн шинжгүй бол холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлагыг хүлээлгэнэ.

_____оОо_____



**ШҮҮХ ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭ**

д/д	Шинжилгээний төрөл	Төлбөрийн хэмжээ /төгрөгөөр/
Амбулаторийн үзлэг, оношилгоо, шинжилгээ		
1	Нарийн мэргэжлийн эмчийн үзлэг /нүд, чих, хамар хоолой, эмэгтэйчүүд/	10.000
2	Бэлгийн гэмт хэргийн үзлэг	10.000
3	Эдийн шинжилгээ	10.000
4	Гэмтлийн зэрэг тогтоох үзлэг	8.000
5	Нас тогтоох үзлэг	8.000
6	ЭХО-д харуулах	10.000
7	Рентген зураг авах	20.000
8	Компьютер томографийн зураг унших	4.000
9	Рентген зураг унших	3.000
Лабораторийн шинжилгээ		
1	ДНХ-ээр эцэг, эх тогтоох /нэг хүний/	100.000
2	Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис тодорхойлох шинжилгээ	45.000
3	Шээсэнд мансууруулах бодис тодорхойлох шинжилгээ	30.000
4	ДНХ-ийн аргаар хийх бактериологийн шинжилгээ	15.000
5	Бичил харуурын аргаар хийх бактериологийн шинжилгээ	8.000
6	Ийлдэс судлалын аргаар хийх бактериологийн шинжилгээ	5.000
7	Спиртийн агууламж тодорхойлох шинжилгээ	5.000
8	Цусны бүлэг тогтоох	3.000
Цогцост хийх шинжилгээ		
1	Гадаад иргэний цогцост хийх шинжилгээ	800.000
2	Шарил дахин шинжлэх /Эксгумаци/	300.000
3	Хэн болох нь тодорхойгүй цогцсыг оршуулсаны дараа ар гэр нь тодорч, ёс заншлын дагуу оршуулах хүсэлт гаргавал цогцсыг оршуулсан газраас нь гаргаж өгөх ажлын болон тээвэрлэлтийн зардал	300.000
4	Цогцост хийх шинжилгээ /18 наснаас дээш/ Үүнд цогцосыг задлан шинжлэх, спиртийн агууламжийг тодорхойлох, түүнчлэн эд эсийн шинжилгээг хийж, цусны бүлгийн тогтоох болон засал хийх төлбөр багтсан болно. Мөн хорт болон мансууруулах бодис хэрэглэсэн эсэх, бусад нэмэлт лабораторийн шинжилгээнүүд хамаарна.	60.000
5	Цогцост хийх шинжилгээ /0-18 насны/	30.000
6	Иргэдийн хүсэлтээр цогцос хөргөгчинд хадгалахад хоногийн	20.000
7	Шинжилгээ хийгдсэн цогцсыг 3 хоног хөргөгчинд үнэгүй хадгална. 3 хоногоос дээш хугацаагаар хадгалсан тохиолдолд хоногийн	10.000
8	Зориулалтын машинаар цогцос тээвэрлэх зардал	5.000 /км тутамд/



д/д	Зардлын нэр	Үнэлгээ /төгрөгөөр/
1	1.1. Насанд хүрсэн хүн	40.000
	1.2. Хүүхэд	20.000
	1.3. ДНХ-ийн шинжилгээ	60.000
2	Хөргөгчинд цогцос хадгалсны хөлс /нэг бүрийн/	5.000
3	Тээврийн зардал	20.000
4	Цогцос оршуулах, нүх ухаж бэлтгэх ажлын хөлс /нүх тутамд/	45.000
5	Шарилын хайрцаг /том хүн/	173.500
	Шарилын хайрцаг /хүүхэд/	106.500
Ороох боох материал, уут, хадаг, ариутгал, хаягжуулалт		
6	6.1. Ороох боох материал /1м 3000/	6.000
	6.2. Хадаг	1.500
	6.3. Дугаар, хаягжуулсан самбар	4.000
	6.4. Ариутгал, цэвэрлэгээний болон халдваргүйжүүлэх бодис /хүн тус бүрт/	3.000
7	Оршуулгын ажил гүйцэтгэхэд оролцсон нэг хүний ажлын хөлс /цогцос бүрт/	50.000
8	Талийгаачийн буянд зориулж ном уншуулах /талийгаач тус бүрт/	3.000
9	Гэрэл зураг боловсруулах зардал CD, альбом /тус бүр 3 хувь угаах/	2.000
10	Нэг удаагийн халдвар, хамгааллын хувцас /1ширхэг/	25.000
Нийт дүн		Том хүн- 438.000
		Хүүхэд- 351.000